

**➤ Засвар үйлчилгээ хариуцсан Менежер**Улаанбаатар  
Ажлын байрны код: SM0301**Зөв хандлагатай, чадвартай мэргэжилтэн та бүхнийг :**

- ✓ Өсөн дэвших боломжтой ажлын байрны таатай орчин
- ✓ Өрсөлдөхүйц цалин
- ✓ Хувь хүний болон мэргэжлийн хувьд хөгжих боломжууд
- ✓ Хувийн эрүүл мэндийн даатгал
- ✓ Улирлаар олгох гүйцэтгэлийн урамшуулал зэрэг боломжууд хүлээж байна.

Бид Улаанбаатар дахь Засвар үйлчилгээний газарт **Засвар үйлчилгээ хариуцсан Менежер** шалгаруулж авна.

**Гүйцэтгэх үндсэн үүрэг:**

Засвар үйлчилгээний газрын даргын шууд удирдлагад ажиллах ба компанийн гагнуур, токарь, сэргээн засварлалтын багийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зааварчилгаагаар хангаж ажиллана. Мөн түүнчлэн:

- Харилцагч, үйлчлүүлэгч болон ажилтнуудыг аюулгүй ажлын байраар хангах
- Засвар үйлчилгээний газрын бүхий л үйл ажиллагаанд холбогдох бодлого, дүрэм журмын хэрэгжилтийг хянаж ажиллах хүч, эд ангийн борлуулалт болон бусад үйлчилгээг зорилтот хэмжээнд ажиллаж байгаа эсэхэд хяналт тавин үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах
- Харилцагчтай үр дүнтэй, нөхөрсөг харилцааг бий болгох, хэвээр хадгалах
- Гадаад болон дотоод харилцагчийн үйлчилгээг өндөр түвшинд хадгалах замаар засвар үйлчилгээний багийг удирдан чиглүүлж зорилго, зорилтын биелэлтэнд дэмжлэг үзүүлэх
- Сар бүрийн холбогдох тайлангуудыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх
- Засвар үйлчилгээний газрын даргыг эзгүйд түүнийг орлон ажиллаж Засвар үйлчилгээний газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлэн бизнесийн тогтмол өсөлтөнд дэмжлэг үзүүлэн ажиллах
- Монгол ажилтнуудыг өөрсдийн мэргэжлийн болон ерөнхий ур чадвараа бүхий л түвшинд тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллах

**Тавигдах шаардлага:**

Энэхүү албан тушаалд засвар үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан 3-5 жилийн туршлагатай байх ба холбогдох мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байх шаардлагатай. Мөн түүнчлэн Комацу брэндийн бүтээгдэхүүн, засвар үйлчилгээ, техникийн талаар ерөнхий мэдлэгтэй байна.

- Урт болон богино хугацааны зорилго, зорилтыг тодорхойлон төлөвлөх, хэрэгжүүлэх чадвартай байх
- Инженерчлэлийн үйл ажиллагааг хянах, түүнтэй холбоотой стратеги, бодлого журмыг боловсруулж хэрэгжүүлэх чадвартай байх
- Нөөцийг оновчтой зохион байгуулах чадвартай байх
- Тогтоосон хугацаанд төслийг дуусгаж оновчтой төлөвлөж, зохион байгуулах чадвартай байх
- Багаар болон бие даан ажиллах чадвартай байх
- Харилцагчтай тогтвортой харилцааг хадгалах мэдлэг, туршлагатай байх
- Харилцагчийн үйлчилгээний стандарт, дүрэм журмын талаар зохих мэдлэгтэй байх
- Аюулгүй ажиллагааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай байх
- Компьютерийн холбогдох програм хангамж, тэр дундаа сэлбэг хэрэгсэл болон бараа материалын бүртгэлийн системүүд дээр ажиллах чадвартай байх
- Удирдан зохион байгуулах, манлайлах ур чадварыг эзэмшсэн байх
- Зохион байгуулж, төлөвлөж, ажил үүргийг нь хувиарлах замаар ажилтнуудыг чиглүүлэн зөвлөх чадвартай байх
- Ажилтны сургалт хөгжлийн хэрэгцээг оновчтой тодорхойлж гүйцэтгэлийг үнэлэх чадвартай байх зэрэг болно.

Сонирхсон хүмүүс ажилд орох хүсэлтээ хувийн намтрын хамт **2019 оны 03 дугаар сарын 18-ны** өдрийн 17:00 цагаас өмнө [careers@transwest.mn](mailto:careers@transwest.mn) хаягаар илгээнэ үү.

Трансвест Монголиа ХХК-д ажил горилох хүсэлт гаргасан та бүхэнд талархал илэрхийлье. Бид зөвхөн дараагийн шатны шалгаруулалтад сонгогдсон ажил горилгогчтой холбогдох болно.

**Трансвест Монголиа ХХК тамхигүй орчныг дэмждэг.**